Дотрын өвчинд хэрэглэгдэх, монгол оронд ургадаг эмт ургамлуудын нэршлийг тодруулах

Э.Даваадулам[1], Д.Цэнд-Аюуш[1], Ч.Батнайрамдал[2], Д.Бямбасүрэн[3]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг
[3]АШУҮИС, Био-Анагаахын сургууль, Биохимийн тэнхим
Цахим шуудан: Btd22e002@gt.mnums.edu.mn, Утас: 95965333

Түлхүүр үг:

Уламжлалт анагаах ухаан
Сурвалж зохиол
Төвөд

Товч утга:

Үндэслэл: Монгол улсын нутаг дэвсгэр Арктикийн хүйтэн болон Төв Азийн халуун, хуурай уур амьсгалын шилжилтийн заагт байрласан тул үүнээс шалтгаалан 16 хүрээнд хамаарах 306 овгийн 1220 төрлийн 5107 зүйлийн ургамал байдгаас 35 гаруй овог зүйлийн ургамлыг эмчилгээнд ашигладаг.[1] Улс орон болгон өөрийн оронд ургадаг эмийн ургамлын талаар дэлгэрэнгүй судалгааг хийж, түүгээр эм, био-бэлдмэл үйлдвэрлэдэг. **Зорилго:** Таван цул эрхтний өвчний эмчилгээнд түгээмэл ашиглагддаг монгол оронд ургадаг эмт ургамлын талаарх сурвалж зохиолууд дахь оноосон нэр, ургамлын шинж, үйлдэл хэрэглээг тодотгох болно. **Арга, аргачлал:** Герменевтикийн аргыг ашиглан бичвэрт зохиолууд дахь Монгол оронд ургадаг, фармакологийн өндөр идэвхтэй эмт ургамлын талаарх нэрийн оноолтыг төрөлжүүлэн жагсан. Эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргыг ашиглан сурвалж зохиолуудын нийтлэг болон зөрөөтэй зүйлсийг тогтоохын зэрэгцээ, давтагдаж байгаа ерөнхий зүй тогтлыг илрүүлж, учир зүйг танин шинжилсэн. **Үр дүн:** Судалгаанд Монгол оронд ургадаг 67 төрөл зүйлийн эмт ургамлын шинжлэх ухааны нэршил, сурвалж зохиолууд дахь төвөд нэршил (Анагаах ухааны дөрвөн үндэс, лхантав, шэлгон, шэлпрэн, түнбээ-димэд-шэлжимэлон), үйлдэл хэрэглээг тодруулан илэрхийлсэн. Таван цул эрхтний өвчиний эмчилгээнд өргөн хэрэглэгдэх нийт 34 овгийн ургамлын нэршлийг тодруулсан. **Дүгнэлт:** МУАУ-ны эх сурвалж зохиолууд болон МУАУ-ны орчин үеийн ном зохиолууд дахь дахь таван цул эрхтний өвчнийг анагаах эмт ургамлын нэршлийг тодруулсан.

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухаан 2000 орчим жилийн тэртээгээс судлагдаж, өв уламжлагдан ирсэн. Эмт ургамлын эмчилгээний шинж чанарыг эмч нар олон зуун жил судалж, үр дүнгийн нь үзэж, олон хүнийг эмчилж эдгэрүүлэн, орчин цагт улам нарийвчлалтайгаар судлан, дэлхий дахинд таниулж байна. Монгол эмч нар өөрийн орны эмийн ургамлыг бүртгэн хэрэглэх системтэй болгохоос гадна ургамлын баялгийн тухай мэдлэгийг дэлгэрүүлэх үүднээс ургамал, амьтан, эрдсээс гаралтай эмийн зүйлийн нэрийг Төвд, Манж, Монголоор бичиж тэдгээрийг таних шинж, ургах газрын онцлог, эмчилгээний ерөнхий чанарыг дурдсан ном судруудыг үлдээсэн байдаг.[2] Дээрх олон оточ, маарамбуудын зохиосон судрууд дээрх ургамлын нэр нэршлүүд зөрөө байдаг тул энэ судалгаагаар нэршлийн ялгаатай байдлыг арил гаж, нэгэн цогц болгох.

Зорилго: Таван цул эрхтний өвчний эмчилгээнд түгээмэл ашиглагддаг монгол оронд ургадаг эмт ургамлын талаарх сурвалж зохиолууд дахь оноосон нэршлийг тодотгоход оршино.

Зорилт:

1. Монголын уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолууд дахь таван цул эрхтний өвчнийг анагаах эмт ургамлын нэршлийг тодруулах
2. Таван цул эрхтний өвчний эмчилгээнд хэрэглэгдэх эмт ургамлын талаар орчин үеийн ном зохиол дахь нэршлийг харьцуулах

Арга, аргачлал: Бидний судалгаа АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар судалгааны ажлын арга зүйг 2021 оны 12 сарын 24-д хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг авсан.

(Протокол №2021/3-13)

Судалгааны загвар: Сурвалж судлал, эх бичиг судлал.

1. Герменевтикийн аргыг ашиглан бичвэрт зохиолууд дахь Монгол оронд түгээмэл ургадаг, фармакологийн өндөр идэвхтэй эмт ургамлын талаарх нэрийн оноолтыг төрөлжүүлэн жагсаасан.
2. Эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргыг ашиглан сурвалж зохиолуудын нийтлэг болон зөрөөтэй зүйлсийг тогтоохын зэрэгцээ, давтагдаж байгаа ерөнхий зүй тогтнолыг илрүүлж, учир зүйг танин шинжилсэн.
3. Дескриптив судалгааны аргыг ашиглан эмт ургамлын оноосон нэршил, ургамал зүйн шинж, үйлдэл хэрэглээ харьцуулан мэдээ, мэдээллийг тайлбарлах, задлан шинжлэв.
4. Анализ-синтезийн арга зүйг ашиглан уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолууд дээрх болон орчин үеийн ном зохиолууд дээрх эмт ургамлын талаарх мэдээлэл цуглуулан дүгнэлтийг хийсэн.

Үр дүн: Судалгаанд Монгол оронд ургадаг таван цул эрхтний өвчнийг анагаах нийт 67 зүйлийн эмт ургамлын шинжлэх ухааны нэршил, сурвалж зохиолууд дахь төвөд нэршил, нутгийн нэршил, үйлдэл хэрэглээг тодруулан илэрхийлсэн. Нарийвчлан судлахад нийт таван цул эрхтний (зүрх, уушги, элэг, дэлүү, бөөр) өвчний эмчилгээнд өргөн хэрэглэгдэх 34 овгийн ургамлын нэршлийг тодруулсан. Дээрх ургамлаас Зүрхний өвчинд 13 зүйл (судалгаанд хамрагдсан ургамлын 19.4%), Уушгины өвчинд 18 зүйл (26.8%), Дэлүүний өвчинд 10 зүйл (14.9%), Элэгний өвчинд 13 зүйл (19.4%), Бөөрний өвчинд 13 зүйл (19.4%) ургамлууд орсон.

Эдгээрээс нэг наст өвслөг ургамал 7%, хоёр наст өвслөг ургамал 5%, олон наст өвслөг ургамал 63%, модлог ургамал 3%, сөөглөг ургамал 7%, сөөгөнцөр ургамал 7% тус тус байна.

Хэлцэмж: Эртний араб, Энэтхэг хэлэнд олон тохиолддог адил бус үгээр нэг утга илэрхийлж, нэг юмыг олон янзаар нэрлэн бичиг зохиолын хэлнээ өргөн хэрэглэгддэг илт өгүүлэх нэрийг “Аливаа юмс үзэгдэлийн хүн амьтны бусдаас ялгагдах онцлог шинж анарыг олон янзаар илтгэн өгсөн олон нэр болон тэдгээр бодгал бүхний хоорондын төстөй талуудыг харуулсан жишиж өгсөн дундын нийтлэг нэр” гэсэн байдаг. Санскритаар abhidhana гэх бөгөөд abhi- илт тодорхой, dhana-нэр өгүүлэл, хоч, цол өгүүлэхүй зэрэг утгатай. Эмийн түүхий эдийн нэрийг Энэтхэгийн Аюурведийн анагаах ухаанаас өвлөгдсөн ч Төвөдийн эмч, эрдэмтэд өөриймсүүлж тайлбарлах талаар нөр их ажлыг хийсэн. Эдгээр нэрүүд нь цаашдаа уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эд болон эмт ургамлын нэрийг бүрэлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Судлаач М.Хастаны 2008 онд “Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэх зарим эмийн ургамлын нэрийн дүйлгэн оноох тухай асуудалд” бүтээлд Уламжлалт анагаах ухааны хий өвчнийг анагаах эм, шар өвчнийг анагаах эм, цусны өвчнийг анагаах эм, бадгана өвчнийг анагаах эм, нянг нядлах эм, яр шархыг анагаах эм, бэтэг анагаах эм, шимжүүлэн тамиржуулах эмийн найрлагад ордог эмт ургамлыг судалсан. Мөн 2014 онд С.Авирмэд Гүн Гомбожавын Эмийн нэршлийн төвөд, хятад хэлний хадмал оршвой зохиолын харьцуулсан судалгаа хийсэн энэхүүсудалгаанд тухайн онцлон авсан эх сурвалж зохиол дахь эмийн ургамлын түүхий эдийн нэршлийн оноолтын зөрөөтэй асуудлыг гаргаж тодорхой болгосон бол харин бидний судалгааны ажилд энэхүү сэдвийн хүрээн 34 овгийн 67 зүйл ургамлын олон улсын нэршил, төвөд, гадаад болон нутгийн өвөрмөц нэршил зэрэг нэг зүйлийн маш олон нэршлийг нэгтгэн хоёр судалгааны бүтээлэй ха

Дүгнэлт:

1. Монгол оронд ургадаг таван цул эрхтний өвчнийг анагаах МУАУ-ны эх сурвалж болох Анагаах ухааны дөрвөн үндэс, Болор бөмбөлөг, Болор эрх и, Түмбии дэмид шэлжилон, Манаглхантав эдгээр номонд нийт 34 овгийн 67 зүйл эмт ургамлын (Төвөд нэр, Монгол нэр) нэршлийг мөн эмт ургамлын амт, эрдэм, чадал, гадан байдал, үйлдэл хэрэглээг тодруулсан.
2. Монгол оронд ургадаг таван цул эрхтний өвчнийг анагаах МУАУ-ны орчин үеийн ном сурах бичигт (МУАУ-ны сэргэн мандалтын үе 1989 оноос өнөөг хүртэлх үеийн бүтээлүүд) дахь нэршлийг нийт 34 овгийн 67 зүйл эмт ургамлын шинжлэх ухааны нэршил (Латин), гадаад улс орнууд дахь нэршил (Русский, english), тухайн ард түмний дундах аман яриан дахь нэршлийг мөн эмт ургамлын амт, эрдэм, чадал, гадан байдал, үйлдэл хэрэглээг тодруулсан.

Талархал: Уг судалгаанд туслалцаа үзүүлсэн АШУҮИС-ийн МАУОИС-ийн Уламжлалт жор судлалын тэнхим багш нар болон ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан хамт олонд талархаж байгааг илэрхийлье.

Ном зүй:

1. *Энхжаргал Д, Баясгалан Б, Пүрэвсүрэн С., Фармакогноз УБ хот 2018 он х20-55*
2. *Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П., Монгол эмийн судлал УБ хот 2013 он. х 50-65*
3. *Алимаа Т, Цэнд-Аюуш Д, Цэрэнцоо Б, Батнайрамдал Ч., Уламжлалт анагаах ухааны онолын үндэс УБ хот 2013 он. х15-45*
4. *Лигаа У, Даваасүрэн Б, Нинжил Н., Монгол орны эмийн ургамлыг өрнө, дорны анагаах ухаанд хэрэглэхүй УБ хот 2006 он. х45-236*
5. *Лигаа У. Монгол орны ашигт ургамал УБ хот 1982 он х103*
6. *Лигаа У. Монгол орны жимс, жимсгэнэт ургамал. УХГ УБ хот 1981 он х100*
7. *Володя Ц, Цэрэнбалжир Д, Ламжав Ц. Монгол орны эмийн ургамал УБ хот 2008 он. х23-200*
8. *Хайдав Ц. Монголын анагаах ухаанд хэрэглэдэг эмийн зарим ургамлын нэр томъёо.ШУАХГ УБ хот 1965 х134*
9. *Хайдав Ц, Төмөрбаатар Н, Цэнд-Аюуш Г., Монгол Төвөд анагаах ухаанд хэрэглэгддэг мод, үрийн эмийн зүйлс УБ хот 1996 он. х 55-65*
10. *Хүрэлчулуун Б, Батчимэг Ө. Монгол орны ургамлын гаралтай зарим эмийн түүхий эдийн лавламж УБ хот 2006 он. х10- 77*
11. *Шатар С. Мөнх ногоон ургамлын эфирийн тос УБ хот ШУАХГ 1975. х 114*

Identify the names of medicinal plants used in internal medicine and growing in mongolia

Davaadulam E[1], Tsend-Ayush D[1], Batnairamdal Ch[2], Byambasuren D[3]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Mongolian Central Medical Hospital, MNUMS
[3]Department of Biochemistry, School of Biomedicine, MNUMS
E-mail: Btd22e002@gt.mnums.edu.mn, Tel: 95965333

Background: Mongolia is located on the border of the Arctic Cold and Central Asia's hot and dry climates, so there are 5207 species of plants in 1220 genera of 306 genera belonging to 16 domains, of which more than 35 genera are used for treatment. Each country conducts a detailed study of medicinal plants grown in its own country and uses them to produce medicines and bio-preparations.
Aim: To highlight the names, properties and uses of herbs in Mongolian literature on herbs commonly used in the treatment of diseases of the five major organs.
Materials and Methods:

1. Using the hermeneutic method, the names of the most popular pharmacologically active medicinal plants in Mongolia are listed in the text.
2. Using the comparative method of source study, the commonalities and differences of the sources were identified, as well as the recurring general patterns and the reasoning was analyzed.
3. Descriptive research method was used to compare the names of medicinal plants, their botanical features and actions, and to interpret and analyze the information.
4. Using the analysis-synthesis methodology, information on medicinal plants was collected from traditional medical sources and modern literature.

Results: The study clarified the scientific names of 67 species of medicinal plants growing in Mongolia, Tibetan names in sources, other names and actions. A detailed study identified the names of 34 genera of plants that are widely used in the treatment of diseases of five major organs (heart, lungs, liver, spleen, kidneys). Of these, 13 species were found in heart disease (19.4% of the plants surveyed), 18 species in lung disease (26.8%), 10 species in spleen disease (14.9%), 13 species in liver disease (19.4%), and 13 species in kidney disease (19.4%), included.
Conclusion: Sources of traditional Mongolian medicine and modern literature on traditional Mongolian medicine have identified the names of medicinal plants for the treatment of five major diseases of the organs.

Keywords: Sources, Tibetan, Traditional Medicine